



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Удирдамж, төлөвлөгөө батлах тухай


Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.1.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж"-ийг нэгдүгээр, "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар ханган хяналт тавьж, тухай бүр тайлагнаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд даалгасугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

Улсын онцгой комиссын даргын 2025  
оны... дүгээр тушаалын хавсралт

ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, улсын хэмжээнд гарч буй ой, хээрийн гал түймрийн тоо, хохирлыг бууруулахад бүх шатны Онцгой комисс, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг төлөвлөх, хамтын ажиллагааг зохицуулах, гарсан гал түймрийг шуурхай унтраах, удирдлага зохицуулалтаар хангах, нөөц хангалтыг зохион байгуулах, гал түймрийн дараа авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа

2.1. Арга хэмжээний удирдамжийг бүх шатны Онцгой комисс, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, төрийн байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

2.2. Удирдамжийн хэрэгжилтийг Улсын онцгой комиссын ажлын алба нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

2.3. Удирдамжийг 2025 онд хэрэгжүүлж ажиллана.

Гурав. Харилцан ажиллагаа, мэдээлэл солилцох чиглэл

3.1. Онцгой комисс, Онцгой байдлын байгууллага ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангаж, харилцан ажиллагааг уялдуулан зохион байгуулах;

3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс, Онцгой байдлын байгууллага нь нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг бүх төрлийн холбоо, мэдээллийн хэрэгслийг ашиглан зохион байгуулах, Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газрын хариуцсан нэгж болон Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн зохицуулагчийг мэдээ мэдээллээр хангах.

Дөрөв. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

4.1. Улсын онцгой комисс:

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, тэмцэх чиглэлээр Улсын онцгой комиссын албан даалгавар, төлөвлөгөө баталж, бүх шатны Онцгой комисст хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн аймгуудад нөөц, хангалтыг зохион байгуулах талаар Засгийн газарт санал хүргүүлэх, зардлыг шийдвэрлэх;

4.2. Бүх шатны Онцгой комисс:

Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийг биелүүлэх, ой, хээрийн гал түймэр гарсан үед шуурхай удирдлагаар хангах, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын албан даалгавар, төлөвлөгөө, өгсөн үүргийг хэрэгжүүлэх;

4.3. Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба: /Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам/

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ой, хээрийн гал түймрийн хохирлын үнэлгээг хийх ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх, хяналт тавих, цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, сумны нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай үед шуурхай ашиглах нөөцийг бүрдүүлэх, холбогдох байгууллагатай хамтран ой, хээрийн гал түймрээс хамгаалах зурвас шинээр болон сэргээн байгуулах, мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт дадлагыг зохион байгуулан ажиллах;

Холбогдох хууль, журамд заасан эрх үүргийн хүрээнд ажиллагааг хэрэгжүүлэх;

4.4. Хил хамгаалах ерөнхий газар:

Хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр, хөрш зэргэлдээх орнуудын хил давж орсон, гарсан ой, хээрийн гал түймрийг унтраах, түймрийн тархалтыг таслан зогсоох, унтраах ажиллагаа явуулах үед хоёр улсын томилгоот алба хаагч, иргэдийг хялбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх асуудлыг хоёр улсын Засгийн газар хоорондын байгуулсан хэлэлцээр бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, алба хаагчдад ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр аймаг, нийслэл, сум дүүргийн Онцгой байдлын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах;

4.5. Онцгой байдлын ерөнхий газар:

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр гарсан үед удирдлага зохион байгуулалтаар хангах арга хэмжээг хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах алба, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн ой, хээрийн гал түймэртэй тэмцэх, унтраах үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, зааварчилгаа, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, дэмжлэг үзүүлж, олон нийтэд сурталчлах;

4.6. Хэв журам сахиулах алба: /Цагдаагийн ерөнхий газар/

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой байдлын байгууллага, Байгаль орчны газартай хамтран эргүүл, хяналтын цэгт ажиллах, ой хээрийн гал түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А/10 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журам, Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, Цагдаагийн ерөнхий газрын Экологийн Цагдаагийн албаны дарга нарын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдөр баталсан ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

4.7. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага:

Нутаг дэвсгэрийн хэмжээнд хязгаарлалт болон бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх захирамж гаргах, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх журам"-ын хэрэгжилтийг хангах, ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд шаардагдах төсөв, хөрөнгө шийдвэрлэх, нөөц бүрдүүлэх, захиран

зарцуулах, гамшгаас хамгаалах мэргэжлийн албад, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг мэргэжлийн байгууллагатай хамтран сургаж, дадлагажуулах, ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааны үед мэргэжлийн байгууллагад хүн хүч, техник хэрэгсэл, хүнс, шатахууны дэмжлэг үзүүлэх;

4.8. Орон нутгийн гамшгаас хамгаалах алба:

Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Ой, хээрийн гал түймэр унтраах ажил оролцож байгаа иргэдийн хувийн хангамжид байх зүйлс, заавал эзэмшсэн байх арга техникийн жагсаалт” –д заасныг хэрэгжүүлэх, орон нутгийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, шуурхай унтраах арга хэмжээг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;

4.9. Сайн дурын хэсэг:

Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Ой, хээрийн гал түймэр унтраах ажилд оролцож байгаа иргэдийн хувийн хангамжид байх зүйлс, заавал эзэмшсэн байх арга техникийн жагсаалт” –д заасныг хэрэгжүүлэх, ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагаанд аюулгүй байдлаа хангаж оролцох, Гамшгаас хамгаалах, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн ажиллах журмаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;

4.10. Хүнс, хөдөө аж ахуйн алба

Ой, хээрийн гал түймрийн аюултай үед ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын байнгын болон хөдөлгөөнт цэгүүдэд үүрэг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед зурвас татах техник, механизм, ус тээвэрлэх зориулалт бүхий автомашин техникийн дэмжлэг үзүүлэх;

4.11. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам

Ой, хээрийн гал түймрийн аюултай үед ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

4.12. Сангийн яам:

Гамшгаас хамгаалах тухай хууль, Сангийн сайдын тушаал, холбогдох дүрэм, журамд заасны дагуу ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад гамшиг ослын томилолтыг бүрэн олгох асуудлыг шийдвэрлэх;

4.13. Эрүүл мэндийн алба:

Ой, хээрийн гал түймрийн голомтод бэртэж, гэмтсэн, түлэгдсэн иргэд, алба хаагчдад эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх, олон хоног үргэлжилсэн ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд, удаан хугацаагаар ажилласан алба хаагчдыг сэргээн засах эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

Тав. Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, зардал

5.1. Төлөвлөгөөний биелэлтийг Улсын онцгой комиссын ажлын албанд 6 дугаар болон 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор албан бичгээр тус тус ирүүлнэ.

5.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг Улсын төсөв, орон нутгийн төсөв, гамшгаас хамгаалах зардлаар шийдвэрлэх.

Улсын онцгой комиссын даргын 2025 оны  
01 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

VXA0168

**ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хэрэгжүүлэх ажил	Төсөв /төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /1-4 дүгээр улирал/	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Нэг.Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр							
1	Монгол Улсын Шадар сайд, УОК-ын даргын албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	Монгол Улсын Шадар сайдын 2024 оны 1 дүгээр сарын 02 дугаар албан даалгавар батлагдсан.	Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, хөрөнгө шийдвэрлэгдэж, орон нутгийн чадавхи нэмэгдэж, бэлтгэл бэлэн байдал хангагдана.	I-IV улирал	УОКАА	ГХА ОБЕГ ХХЕГ
2	ОБЕГ-ын даргын албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах	Үйл ажиллагааны зардлаар	ОБЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 02 дугаар албан даалгавар батлагдсан.	Онцгой байдлын байгууллагын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдал хангагдана.	I-IV улирал	ОБЕГ	ОБГ
3	Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр орон нутгийн нөөц бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах	Орон нутгийн төсөв, Гамшгаас хамгаалах зардал	Жил бүр батлагддаг.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ой, хээрийн гал түймэртэй тэмцэх бэлтгэл, бэлэн байдал хангагдана.	I-IV улирал	АНОК	ОБГ
4	Хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр хөрш орнуудын холбогдох байгууллагатай ой, хээрийн гал түймэртэй	Орон нутгийн төсөв, Гамшгаах хамгаалах зардал	БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн үзэмчин хошуу, Монгол Улсын Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар хоорондын "Хил орчмын	Хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард	II улирал	ОБГ	ХХЕГ

	тэмцэх уулзалт байгуулах	чиглэлээр зохион		ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх чиглэлээр санал солилцох хурал” 2024 оны 05 дугаар сард, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Онцгой байдлын яам, Улаан хотын Онцгой байдлын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын хамтарсан уулзалт 2024 оны 09 дүгээр сард тус зохион байгуулагдсан.	Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилт хангагдана.			
5	Хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр хөрш орнуудын холбогдох байгууллагатай ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр хамтарсан дадлага, сургалт зохион байгуулах	Орон нутгийн төсөв, Гамшгаах хамгаалах зардал	ОХУ-ын Чита мужийн Онцгой байдлын газар, Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Хил хамгаалах байгууллагатай хамтран 2024 оны 05 дугаар сард, 2024 оны 09 дгээр сард БНХАУ-ын ӨМӨЗО-ны Онцгой байдлын яам, Улаан хотын Онцгой байдлын газар Онцгой байдлын ерөнхий газар, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын хамтарсан дадлага сургалт тус тус зохион байгуулсан.	Хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард улсын засгийн газар хоорондын 2022 оны 2 дугаар сарын хэлэлцээрийн хэрэгжилт хангагдана.	II-III дугаар улирал	ОБЕГ	ХХЕГ	
6	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн	Орон нутгийн төсөв,	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ой,	I улирал	ОБГ	АНОК	

	гамшгас хамгаалах алба, мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг хамруулан ой, хээрийн гал түймэртэй тэмцэх штабын дадлага, сургалтыг зохион байгуулах	Гамшгаах хамгаалах зардал	02 дугаар албан даалгавар хүрээнд штабын дадлага сургалтад ОББ-ын 535 алба хаагч, мэргэжлийн ангийн 2254 хүн, 152 автомашин, сайн дурын хэсгийн 1214 хүн, 194 автомашин хамрагдсан	хээрийн гал түймэртэй тэмцэх бэлтгэл, бэлэн байдал хангагдана.			
7	Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилчдад ой, хээрийн гал түймэр унтраах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль бусад холбогдон гарсан дүрэм, журмыг судлуулан, сургалт дадлагыг тогтмол зохион байгуулж, хэвшүүлэх	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, дүрэм, стандартын чиглэлээр 2024 онд 297 удаагийн, 670 цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 5481 албан хаагч хамрагдаж, 5896 алба хаагчдад ХАБ-ын зааварчилгаа танилцуулж, баталгаажуулсан.	Алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаж, ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ур, чадвар дээшилнэ.	I-IV улирал	ОБГ	-
8	Ой, хээрийн гал түймрийн аюултай үед ойд зорчих иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, хязгаарлах, байнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэгийг ажиллуулах ажлыг холбогдох байгууллага, хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах	Орон нутгийн төсөв, Гамшгаах хамгаалах зардал	2024 онд хөдөлгөөнт эргүүлийн 249 цэг байгуулж давхардсан тоогоор 2065 алба хаагч, 449 автомашинтай, онцгой байдлын байгууллагаас 1215 алба хаагч 152 автомашинтай ажилласан	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ойн бүс, нийслэлийн ногоон бүс дэх ой, хээрийн гал түймрийн тоо буурч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ сайжирна.	3 дугаар 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл	АНОК	ОБГ ЦБ БОГ ХХААГ

9	Ойн бүс, ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны бааз зэрэг үйлчилгээний байгууллагуудад гал түймрийн улсын хяналт шалгалтыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	2024 оны хяналт шалгалтад 1772 аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хамрагдаж, 9606 зөрчил, дутагдал илрүүлж, 4758 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулсан	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ойн бүс, нийслэлийн ногоон бүс дэх ой, хээрийн гал түймрийн тоо буурч, урьдчилан сэргийлэх арга хэмжээ сайжирна.	3 дугаар 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл	ОБЕГ	ССЗЯ ЦЕГ БОУАӨЯ
10	Ой, хээрийн гал түймрийн аюултай үед урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулж, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Орон нутгийн төсөв, Гамшгаах хамгаалах зардал	Урьдчилан сэргийлэх чиглэлээр 2024 онд олон нийтийн цахим хуудсаар давхардсан тоогоор 4194 удаа 7175 цаг сэрэмжлүүлэг, мэдээ мэдээлэл хүргэж, 36,410,701 төгрөгийг зарцуулсан. Алдвал галдана нөлөөллийн аяныг 2021 онд зохион байгуулсан.	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ой, хээрийн гал түймрийн аюулын талаарх мэдлэг дээшилж, түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ сайжирна.	I-IV улирал	АНОК	БОУАӨЯ ССЗЯ ХХААХҮЯ ОБЕГ
11	Ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөр нутгуудад урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр томилгоот хөдөлгөөнт бүлгүүдийг томилж, ажиллуулах	Орон нутгийн төсөв, Гамшгаах хамгаалах зардал	2024 онд Хэнтий аймгийн Баян-Адарга, Баян-Овоо, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Норовлин сумдад, Дорнод аймгийн Матад сумдад хөдөлгөөнт бүлгийг томилон, Дорнод аймаг 14,313,200 төгрөг, Хэнтий аймаг 20,000,000 төгрөрийг төсөвлөж ажиллуулсан.	Ой, хээрийн гал түймрийн гаралт, давтамж өндөр Сэлэнгэ аймгийн Мандал сумын Барчулуут, Ар гахайт, Түнхэл тосгон Өлгий ам, Булган аймгийн Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал, Хэнтий аймгийн Баян-Адарга, Баян-Овоо, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Норовлин, Дорнод аймгийн Матад,	I-IV улирал	АНОК	БОГ ХХААЯ



				Гурванзагал, Чойбалсан, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Хадын булаг баг, Дарьганга, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Цагаандаваа зэрэг газруудад байнгын болон хөдөлгөөнт бүлэг ажиллуулах.			
12	Түймэрт өртөж болзошгүй, нутаг дэвсгэрийг хамгаалах, түймрийн тархан дэлгэрэлтийг зогсоох зорилгоор хамгаалалтын зурвас татах ажлыг орон нутгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр БОУАӨЯ, ХХЕГ-аар гүйцэтгүүлэх	Улсын төсөв	Хил хамгаалах ерөнхий газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газартай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийн хүрээнд 405,000,000₮ төгрөгийн санхүүжилтээр 503 км урт ой, хээрийн түймрээс хамгаалах шороон зурвас сэргээсэн.	Ой, хээрийн гал түймрийн тархалт, түймэрт өртөх талбайн хэмжээ багасна.	I-IV улирал	АНОК	ХХЕГ БОУАӨЯ АНОК
Хоёр Ой, хээрийн гал түймэр унтраах чиглэлээр							
13	Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах, унтраах ажиллагаанд дайчлагдан ажиллаж байгаа, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах	-	Улсын хэмжээнд 2024 онд тохиолдсон 137 удаагийн ой, хээрийн гал түймрийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, унтраах ажиллагаанд нийт 4281 хүн, 734 автомашинтай ажилласан.	Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, тактикийн алдаагүй ажиллах.	Тухай бүр	ОБЕГ	ОБГ
14	Үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар	-	Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал авч хэрэгжүүлсэн арга	Удирдлагыг шуурхай мэдээллээр хангаж, түймрийн нөхцөл байдлын	I-IV улирал	ОБЕГ	ОБГ, БОГ, ЦЕГ, ХХЕГ

	удирдлагыг шуурхай мэдээллээр тухай бүр хангах		хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, удирдлага, УОК-ын нарийн бичгийн дарга нарт танилцуулан ажилласан.	талаар танилцуулга, мэдээлэл хүргүүлэх.			
15	Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдлын талаар хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийг бодит мэдээллээр хангах	Үйл ажиллагааны зардлаар	2024 онд олон нийтийн цахим хуудсаар давхардсан тоогоор 4194 удаа 7175 цаг сэрэмжлүүлэг, мэдээ мэдээлэл хүргэж, 36,410,701 төгрөгийг зарцуулсан.	Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх мэдээллийг мэдээллийн бүх сүлжээг ашиглан иргэд олон нийтэд хүргэсэн байна.	I-IV улирал	ОБЕГ	УОКАА
16	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.9 –д зааснаар гамшиг, аюулт үзэгдлийн үед хүн хүч, техник хэрэгслийг татан оролцуулах асуудлыг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагатай хамтран шийдвэрлэх	Орон нутгийн төсөв, Гамшгаас хамгаалах зардал	Улсын хэмжээнд 2024 онд орон нутгаас 2736 иргэн, 551 автомашинтай ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцсон.	Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн гишүүдийн ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаа сайжирч, мэргэжлийн алба хаагчдын ачаалал багасна.	I-IV улирал	АНОК	ОБГ
17	Хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр, хөрш орнуудын хил дамнан гарсан ой, хээрийн гал түймрийг унтраах, түймрийн тархалтыг хязгаарлах үйл ажиллагаа явуулах үед хоёр улсын томилгоот алба хаагч, иргэдийг	-	Дорнод аймаг, Баянтүмэн сум 2 дугаар баг "Сүүл өндөр уул" гэдэг газар 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хилийн зурваст гарсан хээрийн гал түймэрт Онцгой байдлын байгууллагын алба хаагчид хялбаршуулсан журмаар хилийн зурваст	Монгол Улс болон хөрш улсуудын Засгийн газар хоорондын байгуулсан хэлэлцээрийн хэрэгжилт хангагдаж, хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн гал түймрийн тоо, хохирол буурна.	I-IV улирал	ХХЕГ	ОБЕГ

	хялбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх асуудлыг хоёр улсын Засгийн газар хоорондын байгуулсан хэлэлцээр бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах		орж, түймэр унтраах ажиллагааг зохион байгуулсан.				
18	Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний хоол хүнс, хувцас, техник багаж хэрэгсэл, шатахууны хангалтыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд 2024 онд Дорнод, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газраас хүнс, шатахууны хангалтыг зохион байгуулсан.	Ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллаж байгаа алба хаагчдын сэтгэл зүй, чадавхи дээшилнэ.	I-IV улирал	ОБЕГ	УОК
19	Ой, хээрийн гал түймэрт өртөж болзошгүй нутаг дэвсгэрээс хүн ам, эд хөрөнгө, мал сүргийг нүүлгэн шилжүүлэх	-	Түймрийн аюулаас 7 хүн, 1 байшин, 15 гэр, 7 өвөлжөө, хашаа саравч, 200 бог малыг аварсан байна.	Ой, хээрийн гал түймрээс учрах хохирлын тоо хэмжээ буурна.	I-IV улирал	АНОК	ОБГ
20	Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцож байгаа бие бүрэлдэхүүн, иргэний эрүүл мэнд, аюулгүй байдалд хяналт тавих, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагааны зардлаар	Онцгой байдлын ерөнхий газрын даргын албан даалгаварт ой, хээрийн гал түймэр унтраах бүлгийн тоонд 1 эмчийг томилох заалт тусгагдсан.	Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааны үед бэртэж, гэмтэх, хачигт хазуулсан алба хаагч, иргэдэд шуурхай эмнэлгийн анхны тусламж үзүүлж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	I-IV улирал	ОБЕГ	УОК
<b>Гурав. Ой, хээрийн гал түймрийн дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээ</b>							
21	Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын дагуу ой, хээрийн гал түймрийн хохирлын үнэлгээг	Орон нутгийн төсөв, Гамшгаах хамгаалах зардал	Сүүлийн жил буюу 2024 онд нийт гарсан ой, хээрийн гал түймрийн 105 түймрийн хохирлыг үнэлгээг хийлгэсэн.	Ой, хээрийн гал түймрийн хохирлын үнэлгээг хуулийн хугацаанд хийлгэнэ.	Тухай бүр	АНОК	ОБГ

	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, холбогдох байгууллагаар хуулийн хугацаанд хийлгүүлж, дэмжлэг үзүүлэх						
22	Ой, хээрийн гал түймэрт эд хөрөнгө өртөж, хохирол учирсан иргэдэд Засгийн газар, Улсын нөөц хөрөнгөөс холбогдох тусламжийг олгох асуудлыг шийдвэрлэх	Засгийн газрын тогтоол, Улсын нөөцөөс	2023 Дорнод аймагт гарсан хээрийн гал түймрийн улмаас орон гэргүй болсон иргэдэд Монгол-Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын шийдвэрээр 25 ширхэг гэрийг Улсын нөөцөөс олгосон.		Тухай бүр	УОКАА	СЯ
23	Олон хоног үргэлжилсэн ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд, удаан хугацаагаар ажилласан алба хаагчдыг сэргээн засах эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар	2024 онд хойд бүсийн Онцгой байдлын газрын 99, зүүн бүсийн Онцгой байдлын газрын 52, нийт 151 алба хаагчийг сэргээн засах эмчилгээнд хамруулсан.	Алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн байдал дээшилж, эрүүл ахуй хангагдана.	Тухай бүр	ОБГ	ЭМЯ ОБЕГ
24	Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад гамшиг ослын томилолтыг бүрэн олгох асуудлыг шийдвэрлэх	Засгийн газрын тогтоол	2024 онд Онцгой байдлын байгууллагын 1130 алба хаагч ажиллаж, нийт 168,339,000 төгрөгийн гамшиг ослын томилолт олгосон	Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчид гамшиг ослын томилолтыг бүрэн авсан байх.	Жилдээ	ОБГ	СЯ ОБЕГ

Төлөвлөгөөний хавсралтаар:

1. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх 111 дүгээр анги, Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нисдэг тэрэгтэй ажиллах дараалал.
2. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хүн хүч, автомашин, техник хэрэгслийг татан оролцуулж, хамтран ажиллах хуваарийг тус тус хавсаргав.

Товчилсон үгийн тайлбар:

УОК	Улсын онцгой комисс
УОКАА	Улсын онцгой комиссын ажлын алба
ГХА	Гамшгаас хамгаалах алба
СЯ	Сангийн яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ССЗЯ	Соёл, спорт, залуучуудын яам
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ОБГ	Аймаг, нийслэлийн онцгой байдлын газар
АНОК	Аймаг, нийслэлийн онцгой комисс
ЦБ	Аймаг, нийслэлийн цагдаагийн газар
БОГ	Аймаг, нийслэлийн байгаль орчин аялал жуулчлалын газар
ХХААГ	Аймаг, нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар

**ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ХҮНДЭРСЭН ҮЕД ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ 111 ДҮГЭЭР АНГИ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 303 ДУГААР АНГИЙН НИСДЭГ ТЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ДАРААЛАЛ**

д/д	Гамшгийн төрөл	Бэлэн байдалд шилжих хугацаа /цаг, минутаар/	Хийгдэх ажил					
<b>Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх 111 дүгээр анги /Т-1/</b>								
1		Ч+00:00-01:40	111 дүгээр ангитай холбогдож нислэгийн захиалга өгөх	Үндэсний аврах бригадын ой, хээрийн гал түймрийн бүлгийг бэлэн байдлыг хангаж ХАБЭА-н дүрмийн зааварчилгаа өгөх	ҮАБ-аас 111 дүгээр ангийн нисэх талбай руу хөдөлгөөн үйлдэх	111 дүгээр ангийн нисэх талбайгаас нислэг үйлдэх		
			Ч+00:00-00:10	Ч+00:10-00:40	Ч+00:40-01:30 /автомашины түгжрэлийг нэмж тооцох/	Ч+01:30-01:40		
<b>Зэвсэгт хүчний 303 дугаар анги /МИ-171/</b>								
2	Ой, хээрийн гал түймрийн үед	Ч+00:00-02:00	Зэвсэгт хүчний Жанжин Штаб-т албан бичиг хүргэн зөвшөөрөл авах	Зэвсэгт хүчний 303 дугаар ангитай холбогдож нислэгийн захиалга өгөх	Үндэсний аврах бригадын ой, хээрийн гал түймрийн бүлгийг яаралтай цуглар дохиогоор ажиллуулах	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нисэх талбай руу хөдөлгөөн үйлдэх	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нисэх талбайгаас нислэг үйлдэх	Байгууллага хооронд тусгай нийслэг үйлдэх гэрээ байгуулах
			Ч+00:20-00:40	Ч+00:20-00:30	Ч+00:40-01:00	Ч+00:40-01:30 автомашины түгжрэлийг нэмж тооцох	Ч+01:30-01:50	Түймрийг унтрааж дууссаны дараа хийгдэнэ

**ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ХҮНДЭРСЭН ҮЕД ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮН ХҮЧ, АВТОМАШИН, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛЖ, ХАМТРАН АЖИЛЛАХ ХУВААРЬ**

1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр Үндэсний аврах бригад, 09 дүгээр анги, 111 дүгээр анги, 115 дугаар ангийн бие бүрэлдэхүүнийг нэмэлтээр томилон ажиллуулах.

2. Нийслэлийн ногоон бүсэд гарсан ой, хээрийн түймрийн анхны дуудлагаар нийслэлийн Онцгой байдлын газрын Нийслэлийн аврах анги, нэмэлт дуудлагаар харьяа дүүргийн Онцгой байдлын хэлтсийн алба хаагчид, хүч нэмэгдүүлсэн дуудлагаар Үндэсний аврах бригадын бие бүрэлдэхүүнийг унтраах ажиллагаанд татан оролцуулах.

3. Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн ерөнхий зохицуулагч нар ой, хээрийн түймрийн мэдээллийг Гал түймэртэй тэмцэх газрын дарга, Гал унтраах хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нарт шуурхай мэдээлэл өгч хариу арга хэмжээг хамтран төлөвлөнө.

4. Монгол Улсын Шадар сайдын 2024 оны дугаар 24 дүгээр тушаалаар батлагдсан Гал түймэр унтраах дүрмийн 7 дугаар хавсралтаар батлагдсан Гал түймэр унтраах, аврах ангиудын гал түймрийн дуудлагаар гарах дараалал, хүч нэмэгдүүлэн ажиллах хуваарьт Гал түймэр унтраах, аврах ангиуд нь Галын аюулгүй байдлын тухай хууль, “Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавих шаардлага” MNS 6412:2013 стандартад зааснаар үйлчлэх хүрээний зайд үүрэг гүйцэтгэх бөгөөд нэг ангийн хүчин чадлаар унтраах үйл ажиллагааг зохион байгуулах боломжгүй үед хүч нэмэгдүүлсэн дуудлагаар зэргэлдээх сум, дүүргүүдийн гал түймэр унтраах ангийг гал түймэртэй тэмцэх нэгжийн удирдах албан тушаалтан, шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч, зохицуулагчийн шийдвэрээр гарах бөгөөд хэд, хэдэн ангийг зэрэг гаргаж болно гэж заасан байдаг.

№	Ой, хээрийн гал түймэр гарсан аймаг	Нэмэлтээр хамтран ажиллах аймаг, алслагдсан зай (км)			
		Хөвсгөл	Өвөрхангай	Булган	ҮАБ, НОБГ
1	Архангай аймаг	435 км	252 км	282 км	ҮАБ, НОБГ
2	Булган аймаг	Орхон 60 км	Дархан-Уул 260 км	Архангай 282 км	ҮАБ, НОБГ
3	Сэлэнгэ аймаг	Дархан-Уул 98 км	Орхон 279 км	Булган 338 км Төв 363 км	ҮАБ, НОБГ
4	Дархан-Уул аймаг	Сэлэнгэ 98 км	Орхон 180 км	Булган 260 км	ҮАБ, НОБГ
5	Орхон аймаг	Булган 60 км	Дархан-Уул 180 км	Сэлэнгэ 279 км	ҮАБ, НОБГ
6	Хөвсгөл аймаг	Булган 330 км	Орхон 390 км	Завхан 430 км, Тосонцэнгэл 250 км	ҮАБ, НОБГ

7	Төв аймаг	НОБГ 43 км ҮАБ 43 км	Сэлэнгэ 363 км Дархан 266 км	Дундговь 232 км, Дорноговь 266 км Говьсүмбэр 204 км	Хэнтий 313 км
8	Завхан аймаг	Хөвсгөл 430 км	Баянхонгор 209 км	Архангай 256 км	ҮАБ, НОБГ
9	Өвөрхангай аймаг	Баянхонгор 209 км	Архангай 252 км	Булган 374 км	ҮАБ, НОБГ
10	Дорнод аймаг	Сүхбаатар 193 км	Хэнтий 324 км	Говьсүмбэр 500 км Дорноговь-Матад 567 км	ҮАБ, НОБГ
11	Сүхбаатар аймаг	Дорнод 193 км	Хэнтий 220	Говьсүмбэр 458 км, Дорноговь 430 км	ҮАБ, НОБГ
12	Хэнтий аймаг	Сүхбаатар 220 км	Говьсүмбэр 223 км, Дорнод 324 км	НОБГ БНД 540 км	ҮАБ, НОБГ

---oOo---